

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР
ДҮН, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: ӨМА-2025/31-15-ШТА-ГА

ТӨЛӨВЛӨСӨН ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ
БАЙНА.

Даланзадгад хот 2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	2
Дүрслэлийн жагсаалт.....	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	3
БҮЛЭГ 1. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ БҮРДҮҮЛЖ ХУВААРИЛСАН БАЙНА.....	5
1.1 ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг дээр уул уурхайн хандив, тусламжийн эх үүсвэрийг нэмж төлөвлөсөн байна.....	5
1.2 Батлагдсан зарим төсөл, арга хэмжээ иргэдээс авсан саналын жагсаалтад ороогүй, иргэдийн олонхын саналаар дэмжигдээгүй байна	6
БҮЛЭГ 2. ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 30.4 ХУВЬ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.....	9
2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 44 хувьд шууд худалдан авалт хийсэн байна	9
2.2 Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд илэрсэн зөрчил сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна	12
2.3 Зарим төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглахгүй байна	14
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА_.....	17
3.1 Аймаг, сумдын ИТХ журамд заасан хяналтыг тавьж ажилласан гэх боловч тайлагналт хангалтгүй байна.....	17
3.2 Удирдлагын мэдээллийн системд төсөл, арга хэмжээг төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг дутуу, огт оруулдаггүй зөрчил давтан гарсаар байна.....	19
ДҮГНЭЛТ.....	21
ЗӨВЛӨМЖ.....	22
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгийн газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ШТА	Шууд тайлагнах аудит
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТТХ	Төсвийн тухай хууль
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ЗҮГСЖ	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
БОНХОБТХ	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
НААҮГ	Нийтийн аж ахуйн үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	ОНХНС-аас олгох шилжүүлгийг эх үүсвэрээр	5
Хүснэгт 2	ОНХС-ын эх үүсвэр сум бүрээр	6
Хүснэгт 3	2024 оны батлагдсан төсөв, ОНХС-ын төлөвлөгөө	7
Хүснэгт 4	Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт	18
Дүрслэл 1	ХАА-нд баримталсан журмын харьцуулалт /төсөл, арга хэмжээний тоогоор/	10

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянасан, тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад түүврийн арга ашиглан Өмнөговь аймагт орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 3000-3200, 4000, Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;

- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- Засгийн газрын 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, С.Одончимэг, Ж.Болормаа, аудитор Э.Жаргал, Т.Будсүрэн, П.Санчиргарав, Ө.Болортуяа, О.Чойдорж, Э.Жамцдорж нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ БҮРДҮҮЛЖ ХУВААРИЛСАН БАЙНА.**1.1 ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг дээр уул уурхайн хандив, тусламжийн эх үүсвэрийг нэмж төлөвлөсөн байна.**

1.1 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Өмнөговь аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 47,716.0 сая төгрөг байхаар баталсан байна.

Хүснэгт 1 Олгох шилжүүлгийг эх үүсвэрээр задалбал:

/сая.төг/

2024 оны ОНХНС болон улсын төсөв									
№	Сумд	ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг /ТТХ-ийн 60.2.1 орсон/ төлөв гүйц		Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 100% /ТТХ-ийн 60.2.7 орсон/ төлөв гүйц		Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50% /ТТХ-ийн 60.2.7 орсон/ төлөв гүйц		"Тогтвортой амьжиргаа-3" төсөл /ТТХ-ийн 59.1.3/ Урамшуулал төлөв гүйц	
1	Баяндалай	884.8	845.8	4.4	4.4	12.3	12.3	-	-
2	Баян-Овоо	2,076.3	1,974.4	10.8	10.8	138.7	138.7	127.9	127.9
3	Булган	638.7	606.6	-	-	-	-	102.4	102.4
4	Гурвантэс	3,654.6	3,302.2	-	-	167.3	167.3	-	-
5	Даланзадгад	3,487.1	3,338.1	-	-	0.1	0.1	-	-
6	Мандал-Овоо	672.3	641.6	-	-	37.9	37.9	-	-
7	Манлай	1,411.5	1,338.6	0.4	0.4	79.1	79.1	192.5	192.5
8	Ноён	1,695.2	1,491.2	1.1	1.1	118.8	118.8	120.2	120.2
9	Номгон	1,783.4	1,702.9	-	-	74.5	74.5	-	-
10	Сэврэй	665.0	665.0	-	-	-	-	133.4	132.8
11	Ханбогд	3,632.2	3,451.1	49.6	49.6	499.7	499.7	-	-
12	Ханхонгор	1,018.8	969.1	3.3	3.3	27.8	27.8	96.6	96.6
13	Хүрмэн	992.4	948.3	5.6	5.6	19.5	19.5	-	-
14	Цогт-Овоо	703.6	666.0	42.6	42.6	20.1	20.1	100.1	100.1
15	Цогтцэций	2,840.7	2,698.0	164.7	164.7	-	-	291.9	291.9
16	Аймгийн төв	17,437.6	17,265.5	117.9	117.9	1,360.6	1,360.6	-	-
	Дүн	43,594.0	41,904.4	400.5	400.5	2,556.4	2,556.4	1,165.1	1,164.5

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.2 Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгээр 46,025.8 сая төгрөг олгож, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд зааснаас 1,690.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна. Энэ нь ОНХНС-гаас орлого дутуу шилжүүлсэнтэй холбоотой байна.

1.3 Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 19/28 дугаар тогтоолоор татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр 500.0 сая төгрөг, уул уурхайн хандиваар орох орлогыг 5,000.0 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр нийт 3,000.0 сая төгрөг аймгийн ОНХС-д төвлөрүүлсэн байна.

1.4 Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9¹-д заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт 5,000.0 сая төгрөг төлөвлөснөөс Эрдэнэс Таван толгой ТӨХК-ийн хандивын орлого 2,500.0 сая төгрөг төвлөрч 2,500.0 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

1.5 Сумдын ИТХ-ын тогтоолоор Манлай сум уул уурхайн хандиваар орох орлогод 97.9 сая төгрөг "МАК" ХХК-аас, Ханхонгор сум 419.5 сая төгрөг "Хангад эксплорэйшн" ХХК-аас, Цогт-Овоо сум 73.0 сая төгрөг "Аурум металс" ХХК-аас, Цогтцэций сум 550.0 сая төгрөг

¹ Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж

“Эрдэнэс Таван толгой” ТӨХК-аас тус тус орохоор төлөвлөсөн бол бусад сум төлөвлөөгүй байна. Энэ нь зарим сумд ОНХС-ийн хуульд заасан эх үүсвэрийг бүрэн тооцохгүй байгаатай холбоотой байна.

1.6 Малын тоо толгойн албан татварыг 12 сумд 10.0-183.0 сая төгрөгийн хооронд төлөвлөж Баян-Овоо, Булган, Номгон сумд төлөвлөөгүй байна. /Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас/

1.7 Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор ОНХС-ын нийт эх үүсвэрийг 65,974.2 сая төгрөгөөр баталсан байна. Сумдаас Даланзадгад сум хамгийн их буюу 4,894.6 сая төгрөгийн, Сэврэй сум хамгийн бага буюу 864.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Хүснэгт 2 ОНХС-ын эх үүсвэр сум бүрээр:

/сая.төг/

№	Сумд	Нийт эх үүсвэр	
		төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Баяндалай	1,395.5	1,342.0
2	Баян-овоо	3,050.4	2,948.5
3	Булган	1,158.4	1,135.6
4	Гурвантэс	4,654.4	4,302.1
5	Даланзадгад	4,894.6	4,729.7
6	Мандал-Овоо	908.0	871.4
7	Манлай	2,274.2	2,182.0
8	Ноён	2,118.3	1,910.3
9	Номгон	2,204.0	2,123.5
10	Сэврэй	864.5	847.8
11	Ханбогд	5,146.2	4,946.4
12	Ханхонгор	1,876.8	1,743.3
13	Хүрмэн	1,343.8	1,160.8
14	Цогт-Овоо	1,052.5	961.9
15	Цогтцэций	4,810.3	4,057.2
16	Аймаг	28,222.4	25,550.3
Нийт		65,974.2	60,813.0

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.8 ОНХС-ын өмнөх оны үлдэгдэл аймаг, сумд нийт 10,702.4 сая төгрөг баталсан нь нийт эх үүсвэрийг өсгөх шалтгаан болсон байна.

1.9 Эх үүсвэрийг хуулийн хүрээнд нэмэх талаар сумдын Засаг дарга нар бодиттой арга хэмжээ авч ажиллаагүй байна. Цаашид төсөв боловсруулж батлахдаа ОНХС-ийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломжийг судлан арга хэмжээ авч орон нутгийн хөгжилд оруулах хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.2 Батлагдсан зарим төсөл, арга хэмжээ иргэдээс авсан саналын жагсаалтад ороогүй, иргэдийн олонхын саналаар дэмжигдээгүй байна.

1.10 Аймгийн хэмжээнд иргэд 2024 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг цаасан, цахим болон бүлгийн ярилцлага хэлбэрээр өгсөн байна.

1.11 Аудитын явцад сумдын 2024 оны ОНХС-ийн төлөвлөлтийн баримт бичигт тулган баталгаажуулалт хийхэд иргэдийн саналыг аваагүй, багийн иргэдийн олонхын саналаар дэмжигдээгүй зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Номгон сум иргэдийн санал аваагүй 1,173.4 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн,

- Ханхонгор сум иргэдийн санал аваагүй 354.0 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн,
- Цогтцэций сум иргэдийн санал аваагүй 153.1 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн,
- Гурвантэс сум иргэдийн санал аваагүй 549.2 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн,
- Сэврэй сум иргэдийн санал аваагүй 64.1 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн,
- Баян-Овоо сум төсөл, арга хэмжээний саналд 202 иргэн буюу 12% хамрагдсан,
- Даланзадгад сум төсөл, арга хэмжээний саналд 3497 иргэн буюу 20% хамрагдсан,
- Манлай сум төсөл, арга хэмжээний саналд 631 иргэн буюу 35% хамрагдсан,
- Ханбогд сум төсөл, арга хэмжээний саналд 2333 иргэн буюу 30% хамрагдсан,
- Ханхонгор сум төсөл, арга хэмжээний саналд 317 иргэн буюу 19% хамрагдсан,
- Цогтцэций сум төсөл, арга хэмжээний саналд 755 иргэн буюу 15% хамрагдсан байна.

1.12 Энэ нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.3.2², 6.4.1³-т заасантай тус тус нийцэхгүй байна.

1.13 Дээрх зөрчлүүд нь иргэдээс санал авах хэлбэр тохиромжгүй байгаагаас шалтгаалсан байна. Иймд дээрх сумдын Засаг дарга нарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж хүргүүлээ.

1.14 Аймгийн 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг аймгийн урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан байна. Тухайлбал:

- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө

1.15 Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 19/28 дугаар тогтоолоор ерөнхий нэрээр 12 төсөл, арга хэмжээнд нэр төрлөөр задалбал 17 төсөл, арга хэмжээнд 28,222.4 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

1.16 Сумдын ИТХ-ын тогтоолоор нийт 398 төсөл арга хэмжээнд 37,751.8 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Хүснэгт 3 2024 оны батлагдсан төсөв, ОНХС-ын төлөвлөгөө

№	Сумд	Нийт орлого	Нийт зарлага	ОНХС-ын	
				ТАХ-ий тоо	Дүн
1	Баяндалай	3,882.7	3,882.7	42	1,395.5
2	Баян-Овоо	5,974.7	5,974.7	27	3,050.4
3	Булган	3,436.4	3,436.4	25	1,158.4
4	Гурвантэс	40,299.4	40,299.4	16	4,654.4
5	Даланзадгад	45,356.2	45,356.2	25	4,894.6
6	Мандал-Овоо	2,973.5	2,973.5	20	908.0
7	Манлай	5,392.3	5,392.3	37	2,274.2
8	Ноён	4,772.7	4,772.7	41	2,118.3

² ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх

³ Баг, хороодоос ирүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь баг, хорооны иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн эсэх

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

9	Номгон	4,704.8	4,704.8	43	2,204.0
10	Сэврэй	4,438.5	4,438.5	21	864.5
11	Ханбогд	396,995.5	396,995.5	9	5,146.2
12	Ханхонгор	3,906.4	3,906.4	16	1,876.8
13	Хүрмэн	3,573.4	3,573.4	28	1,343.8
14	Цогт-Овоо	3,747.1	3,747.1	22	1,052.5
15	Цогтцэций	74,355.7	74,355.7	26	4,810.3
16	Аймаг	2,091,928.2	2,091,928.2	17	28,222.4
	Нийт	2,695,737.5	2,695,737.5	415	65,974.2

Эх сурвалж: ИТХ-ын тогтоолууд

1.17 Аймаг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр төсөл арга хэмжээнд зарцуулах зардлын хэмжээ нийт төсвийн зарлагын 2.4 хувийг эзэлж байна.

1.18 Аймаг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуульд заасан шалгуур болон төлөвлөлтийн бусад шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталсан байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 2,201.7 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Ханбогд сумын төвийн гудамж, хорооллын хяналтын камер суулгах ажил, Баян-Овоо сумын сургуулийн спорт заалны шалыг засварлах зэрэг ажлууд нь техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөвгүй,
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Ханхонгор сумын төвийн гэр хорооллыг цэвэр, бохир усны сүлжээнд холбох 932.9 сая төгрөг, Цогт-Овоо сумын төвийн дэд бүтцийн шугам сүлжээний өргөтгөл 1,100.0 сая төгрөг, Сэврэй сумын төвийн автозам 7,124.7 сая төгрөгийн ажлуудыг аймгийн ОНТХО-аар хийж гүйцэтгэсэн бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрийг давхардуулж төлөвлөсөн,
- Номгон сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Мал амьтныг халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ядарч доройтсон малын тамир тэнхээ сэргээх эм бэлдмэлийн нөөц бүрдүүлэх" ажлын хүрээнд 50.0 сая төгрөгөөр малчин өрхөд малын эмийн сангийн багц олгосон,
- "ЕБС-ийн биеийн тамирын талбайд тоглоомын талбай тохижуулах ажил"-ийн даалгаварт тоног төхөөрөмжийг суурилуулахад шаардлагатай бетон болон резин шал төлөвлөөгүй,
- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр ХАА-н захын барилгыг тохижуулан ашиглах, ашиглалтад оруулах, Сургуулийн заалны халаалтын шугамыг засварлах, шинэчлэх, Сургуулийн дотуур байрны угаалтуур 00 завсарлах зэрэг ажлууд нь техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөвгүй,
- Малжуулах ажил зохион байгуулах, Залуу малчдыг дэмжих /30 ш гэр/, Ногооны талбай тохижуулах /36 ш хүлэмж/ зэрэг ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлэн иргэдэд дэмжлэг, тусламж хэлбэрээр олгосон,
- Манлай сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Манлай сумыг 2024 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө"-д тусгаагүй Сумын иргэний танхимыг ухаалаг дэлгэц болон бусад тоног төхөөрөмжөөр хангах, Спорт заалны сантехникийг иж бүрэн шинэчлэх, Эрчим хүчний байгууллагад жижиг оврын автомашин авах, Заал цэвэрлэх машин авах зэрэг ажлуудыг төлөвлөсөн,
- Барилгын ажил гүйцэтгэх талбайн газрын зөвшөөрөл олгогдоогүй байхад "Ахуйн үйлчилгээний газрын нэгдсэн том зогсоол хийх" ажлыг төлөвлөж, зориулалтыг өөрчлөн төсвөөс 99.9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан,

- "Ахуйн үйлчилгээний газрын нэгдсэн том зогсоол хийх", "Наадмын талбай, цэнгэлдэх хүрээлэнгийн тохижилт" -ын ажлуудын төсөвт магадлалын дүгнэлт гараагүй,
- Наадмын талбай, цэнгэлдэх хүрээлэнгийн тохижилт, Дулааны шугамын өргөтгөл, шинэчлэл, Гүн өрмийн худаг гаргах, Цахилгааны шугамын өргөтгөл хийх зэрэг ажлууд нь техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, зураг төсөвгүй,
- Ханхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Ханхонгор сумыг 2024 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө"-д тусгаагүй Соёлын төвийн тайзны засвар хөшиг хийх, Багийн гадна тал хашаажуулах, Гамшгаас хамгаалах зэрэг төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн,
- Гамшгаас хамгаалах зардлаас ЗДТГ-ын Ланд-200 автомашинд 26,442.000 төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн,
- Цогт-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Цогт-Овоо сумыг 2024 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө"-д тусгаагүй Гүн өрмийн худаг шинээр гаргах, ЕБС-ийн шаардлагатай тоног төхөөрөмж, Хүүхдийн өрөө тохижуулах, ЕБС-ийн заалыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, Цогт-Овоо улаан ямааны ангилан ялгалт, Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээг сайжруулах зэрэг төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн,
- Зардлын шинж чанартай 2 төсөл, арга хэмжээнд 27.3 сая төгрөг төлөвлөж, зарцуулсан,
- Ноён сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Өвс тэжээл татан төвлөрүүлэх ногоон тэжээл татах" 110.0 сая төгрөг өртөгтэй ажлыг ажлын даалгаваргүй зохион байгуулсан,
- Хүрмэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Хүүхдийн тоглоомын талбай засварлах, шинээр хийх" ажилд гүйцэтгэгч тал үер усны эрсдэлд урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.

1.19 Дээрх зөрчлүүд нь хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлохгүй байгаагаас шалтгаалсан байна. Иймд дээрх сумдын Засаг дарга нарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж хүргүүллээ.

БҮЛЭГ 2. ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 30.4 ХУВЬ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

2.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 44 хувьд шууд худалдан авалт хийсэн байна.

2.1. Аймаг сумдын ИТХ-ын тогтоолоор батлагдсан 65,974.2 сая төгрөгийн 415 төсөл, арга хэмжээнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Үүнээс 14,275.0 сая төгрөгийн 126 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зарлаагүй буюу хэрэгжээгүй байна.

2.2. Энэ нь зарим сумын ОНХС-аар хийхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний төсөв хүрэлцэхгүй, холбогдох зөвшөөрөл гараагүй, эх үүсвэр давхардсан зэргээс шалтгаалсан байна. Цаашид төлөвлөлтийн шаардлагад нийцсэн төсөл арга хэмжээг төлөвлөж байх шаардлагатай байна.

2.3. Тайлант онд аймаг сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр 32,777.6 сая төгрөгийн 302 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. /Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас/

Дүрслэл 1 ХАА-нд баримталсан журмын харьцуулалт /төсөл, арга хэмжээний тоогоор/



Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

2.4. Дээрхээс харахад худалдах авах ажиллагаа зарласан төсөл арга хэмжээний 44 хувь нь 20.0 сая төгрөгөөс доош өртөгтэй ШХА, 35,3 хувь нь Харьцуулалтын, 20.1 хувь нь НТШ, 0,6 хувь нь ГШБ аргыг ашигласан байна. Энэ нь зарим сумд сангийн хөрөнгийг хэт жижиглэж төсвийн байгууллагын урсгал зардлын шинжтэй төсөл арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлж байгаа нь үр өгөөжийг бууруулж байна.

2.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3⁴, 10.5⁵ -д захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг ижил төстэй байдлаар багцлах, батлагдсан төсвийг хуваахгүй байх талаар заасан байдаг.

2.6. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулахдаа ижил, төстэй ажлуудыг багцлаагүй, тендер шалгаруулалт зарлахаас зайлсхийсэн гэж үзэх нөхцөл үүсэж байна. Иймд цаашид ХАА-г хуульд нийцүүлэн зохион байгуулах шаардлагатай байна.

2.7. Аудитын явцад сумдын 2024 оны ОНХС-ийн ХАА-ны баримт бичигт тулган баталгаажуулалт хийхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр “Сумын төвийн өнгө үзэмж, хаягжуулалд, хашаа гудамж талбайг тохижуулах” ажлын тендерийг үнэлэхдээ үнэлгээний хорооны гишүүдийн ирц бүрдээгүй, ТШББ-т заасан шаардлагыг бүрэн хангаагүй байхад “Дархан төгөлдөр говь” ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон,
- “Айл өрхүүдийг цэвэр усны шугам сүлжээнд холбох”, “Малын үүлдэр угсааг сайжруулах шилмэл омгийн цөм сүргээр сүргийн бүтэц сайжруулахад дэмжлэг үзүүлэх” зэрэг ажлыг гүйцэтгэх үнийн саналыг олон нийтэд мэдээлээгүй, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөнөөр нээлттэй сонгон шалгаруулаагүй,

⁴ Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно

⁵ Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно.

- Манлай сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Иргэдийн бүлэг"-ээр 124.5 сая төгрөгийн 7 ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөнөөр нээлттэй сонгон шалгаруулаагүй, худалдан авах ажиллагааг олон нийтэд мэдээлээгүй,
- Ханхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Бэлчээрийн гүн өрмийн худгийн цооног нэмэгдүүлэх худаг гаргах ажил"-ын Үнэлгээний хорооны 3 гишүүн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргаагүй,
- "Багийн гадна тал хашаажуулах /Мандах, Хондот/", "Гамшгаас хамгаалах зардал"-аас хэрэгжүүлсэн өвс тэжээл тээвэрлэх ажлыг гүйцэтгэх үнийн санал ирүүлэхийг олон нийтэд мэдээлээгүй ба ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөнөөр нээлттэй сонгон шалгаруулаагүй,
- Сумын Засаг даргын 2024 оны А/28 дугаар захирамжаар "Жижиг дунд үйлдвэрийн барилга өргөтгөх хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж суурилуулах, хадгалах агуулах барих ажил"-ын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны даргаар сумын ЗДТГ-ын дарга томилогдож, үнэлгээний хорооны зөвлөмж гарган ЗДТГ-ын даргын 2024 оны 03/123 дугаар албан бичгээр гэрээ байгуулах эрх олгож, Нагуру констракшн" ХХК-тай 2024/11 дугаартай гэрээг байгуулж тус ажлыг гүйцэтгүүлсэн,
- Цогт-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн бүлэг болон нөхөрлөлөөр 42.8 сая төгрөгийн 3 ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөнөөр нээлттэй сонгон шалгаруулаагүй, худалдан авах ажиллагааг олон нийтэд мэдээлээгүй байна.

2.8. Дээрх зөрчлүүд нь хууль, журмыг бүрэн судлаагүйгээс шалтгаалсан байна. Иймд дээрх сумдын Засаг дарга нарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж хүргүүлээ.

2.9. ОНХС-ийн 2024 оны хөрөнгөөр нийт 415 төсөл арга хэмжээнд 65,974.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж жилийн эцсийн гүйцэтгэлээр 289 төсөл арга хэмжээнд 39,637.8 сая төгрөгийн гэрээ байгуулан баталгаажсан гүйцэтгэлээр 36,074.3 сая төгрөг олгосон байна.

2.10. Сумдын ОНХС-ийн санхүүжилт зарим ажлуудын бодит гүйцэтгэлд үндэслээгүй илүү олгосон болон санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Номгон сумын ОНХС-ийн хөрөнгөөр "ЕБС-ийн биеийн тамирын талбайд тоглоомын талбай тохижуулах" ажлын даалгаварт тусгасан 4-н амьтны дүрстэй эргэдэг тоглоом, волейболын шон, тор, элсэн талбайн 6.8 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй байхад ажил хүлээлцэх комисс ажлыг хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон,
- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Суманд ёс заншлын өргөө байгуулах" ажлыг хэрэгжүүлээгүй төсөл арга хэмжээний зориулалтыг өөрчлөн тавилга, эд хогшил худалдан авсан, ажлын даалгаврын дагуу хөрөнгө хүлээж аваагүй, ИТХ-ын тогтоолоор батлагдсан арга хэмжээний дагуу санхүүжүүлээгүй,
- Манлай сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Эмээгийн цайны газрыг засварлах" ажлыг гүйцэтгэхдээ тус цайны газрыг засварлаагүй хүндэтгэлийн өргөөнд тоног төхөөрөмж, модон ширээ, авдар, идээний таваг, ууцны таваг, морин хуур, хүлээн авалтын аяга, таваг зэргийг худалдан авч ИТХ-ын тогтоолоор батлагдсан арга хэмжээний дагуу санхүүжүүлээгүй,

- "Сургуулийн 420 хүүхдийн ширээ сандлыг шинэчлэх", "Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж авах" зэрэг ажлын тендер шалгаруулалтын баримт бичиг болон гэрээнд барьцаа хөрөнгө байршуулах талаар тусгаагүй,
- Ханбогд сумын ОНХС-ийн хөрөнгөөр Повертүүл ХХК-тай "Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд гэрэлтүүлэг, камержуулалд хийх" байгуулсан гэрээний дагуу 19.9 сая төгрөгийг сумын барьцаа дансанд байршуулаагүй,
- Ханхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Сумын 100 жилийн ой болохтой холбогдуулан айл өрх байгууллагын хаягжуулалд барилга байгууламжийн өнгө үзэмжийг сайжруулах гадна хашаа шинэчлэх" ажлаас барьцааг 2%-иар тооцсон,
- Цогт-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Дахин дамжуулах ЦТП байгуулах" ажил эхлүүлээгүй байхад 70 хувийн урьдчилгаа санхүүжилт буюу 27.8 сая төгрөгийг гэрээнд тусгаж, санхүүжилт хүссэн албан бичгийг үндэслэн олгосон, гэрээний үүргийн биелэлтийг хангуулж ажиллаагүй,
- Ноён сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Сумын үер усны далан шуудуу барих ажил"-ыг шаардлага хангаагүй иж бүрдэл дутуу баримт бичгийг үндэслэн санхүүжилт олгосон,
- Хүрмэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Худаг засварлах" ажлын 5.0 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг барьцаа данс руу төвлөрүүлсэн,
- "Хүрмэн багийн ногоон байгууламж", "18 дугаар цэцэрлэгийн тохижилт", "Хогийн менежмент"-ын ажилд барьцаа суутгахаар гэрээнд заасан боловч санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2.11. Дээрх зөрчлүүд нь ажлын хариуцлага алдсанаас шалтгаалсан байна. Иймд дээрх сумдын Засаг дарга нарт төлбөр барагдуулах төлбөрийн акт, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, хариуцлага тооцох албан шаардлага, зөвлөмж хүргүүлээ.

2.2 Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд илэрсэн зөрчил сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

2.12. Аймаг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 415 төсөл арга хэмжээнд 65.97462 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 289 төсөл арга хэмжээнд 39,637.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан бол 14,275.0 сая төгрөгийн 126 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байгаа нь төлөвлөгөөний 30.4 хувь төлөвлөсөн үр дүндээ хүрээгүйг харуулж байна. /Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас/

2.13. Энэ нь аймаг, сумд нь төсвийн тодотголоор төсөл, арга хэмжээг нэмж баталснаас худалдан авах ажиллагааны хугацаа оройтсон, огт зарлаагүй, худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч шалгараагүй, холбогдох зөвшөөрлүүд гараагүй зэрэг шалтгаанаар зарим төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

2.14. Цаашид сумдын Засаг дарга нар огт хэрэгжээгүй төсөл арга хэмжээнүүдэд дүн шинжилгээ хийж төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байна.

2.15. Зарим сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд дараах зөрлүүд илэрлээ. Үүнд:

- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Ногоон байгууламж, ойжуулалтыг нэмэгдүүлэх, хамгаалах, хашаалах" ажлыг Дархан төгөлдөр говь ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан боловч ажлын даалгаварт тусгасан ажлыг

хэрэгжүүлсэн эсэх нь анхан шатны баримт болон ургасан модны тоогоор баталгаажихгүй,

- Даланзадгад сумын ОНХС-ийн хөрөнгөөр Авто машингүй гудамж бий болгох ажлын хүрээнд Даланзадгад сумын 2 дугаар багт бий болгосон тоглоомын талбай нь иргэд ашиглах боломжгүй, айлын хашаатай зэрэгцүүлэн булангийн газар байгуулсан нь ойр орчмын иргэдийн дунд бухимдал үүсгэж, талбайг зориулалтаар ашиглах боломжгүй болгосон,
- Малын эрүүл мэндийн багц нийлүүлэх ажлыг 89.3 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн бөгөөд гэрээний дагуу 2025 оны 12 дугаар сард 337 тоо ширхгийг хүлээн авсан боловч 2025 оны 6 сарын 17-ны өдрийн байдлаар 225 багц зорилтод бүлэг буюу малчдад хүрээгүй, агуулахад одоог хүртэл байна,
- "Өглөөний гудамж бий болгох", "Нийтийн эзэмшлийн талбай камержуулах ажил", "Баг тус бүр автомашингүй гудамжтай болох 4,5,7 дугаар баг" зэрэг ажлууд нь төлөвлөлтийн шаардлага хангаагүйгээс гэрээний хугацаанд хэрэгжээгүй 1-2 жил дамжсан, төсвөөс 491.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан ч гүйцэтгэлийг хангуулж, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр ашиг, үр дүнг хариуцаж ажиллаагүй,
- Хүрмэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр Тулга багийн агуулахын барилгын барих ажлын даалгаварт тусгасан төмөр бетон ялуу цутгах болон гадна дотор заслын ажлыг хийж гүйцэтгээгүй
- Ханбогд сумын ОНХС-ийн хөрөнгөөр Гүн өрмийн худаг шинээр гаргах, Алслагдсан багуудын нутаг дэвсгэрт үүрэн телефоны сүлжээг сайжруулах, Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд гэрэлтүүлэг, камержуулалд хийх, Цагаан хад суурьшлын бүсэд ашиглах 50 ковш худалдан авах, Хайрхан багт инженерийн хийцтэй худаг гаргах зэрэг ажлуудад 2023 оны жилийн эцэст гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулаагүй, алданги ногдуулаагүй, хариуцлага тооцоогүй, гэрээг удаа дараа сунган 2 жил дамнуулан хэрэгжүүлсэн,
- "Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж, талбайд гэрэлтүүлэг, камержуулалд хийх" ажил дуусаж Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны А/2293 дугаар захирамжаар байнгын ашиглалтад хүлээн авах улсын комисс томилсон боловч одоог хүртэл хүлээж аваагүй, комисс ажилласан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна,
- Сумын 100 жилийн ой болохтой холбогдуулан айл өрх, байгууллагын хаягжуулалд, барилга байгууламжийн өнгө үзэмжийг сайжруулах гадна хашаа шинэчлэн будах арга хэмжээг "Тэлмүүн доной" ХХК нь ажил дууссан тухай мэдэгдэл ирүүлсэн боловч 2024 оны 07 дугаар сарын 23-нд ЭМТ, 10 дугаар цэцэрлэгээс гүйцэтгэл дутуу, хашаа будаагүй, хаалга хийгдээгүй, өрлөг нь эхнээсээ нурж, хашааны гагнуур шаардлага хангахгүй, байгууллагын хаяг, гэрэлтүүлэг цахилгааны холболт дутуу зэрэг гомдол ирүүлсэн, мөн 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/142 дугаар захирамжаар ажил хүлээн авах комисс томилогдон комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй,
- Цогтцэций сумын ОНХС-ийн хөрөнгөөр Захиалагчийн ажлын зурагт тусгагдсаны дагуу саравч хийгдээгүй, ширээ байхгүй, саравчны суурь, ул хөрсийг нягтруулан элсэн дэвсгэр дээр хийдээгүй, зураг төсөвт 10 ширхэг сандал тусгагдсан боловч 8 ширхэг түшлэгтэй сандал хийгдсэн, хүүхдийн тоглоомын иж бүрэн модон 2 тоглоомыг хуванцар тоглоомоор хийсэн, хүүхдийн тоглоомын талбайд 2 ширхэг модон савлуур зурагт заасныг 1 ширхэг хуванцар савлуур хийсэн, элсний талбайн 4 буланд 4 ширхэг 200 вт-аас доошгүй чадалтай талбай гэрэлтүүлэх хэмжээний гэрэлтүүлэг суурилуулахаар төлөвлөсөн боловч 2 гэрэлтүүлэг суурилуулсан, явган

хүний талбайд нийт 19 ширхэг 50 вт-аас доошгүй чадалтай зам гэрэлтүүлэх хэмжээний гэрэлтүүлэг 19 ширхгийг төсөвлөсөн боловч 10 ширхгийг суурилуулсан байна.

2.16. Дээрх зөрчлүүд нь ажлын хариуцлагагүй, захиалагч хяналтыг дутуу хийсэн зэргээс шалтгаалсан байна. Иймд дээрх сумдын Засаг дарга нарт төлбөр барагдуулах төлбөрийн акт, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж хүргүүлээ.

2.3 Зарим төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглахгүй байна.

2.17. Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгөд түүврийн арга ашиглан зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг шалгахад 4 сумын 806.6 төгрөгийн 7 хөрөнгийг ашиглахгүй, хамгаалалтгүй байна. Үүнд:

- Даланзадгад сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн вто машингүй гудамж бий болгох ажлын хүрээнд Даланзадгад сумын 2 дугаар багт бий болгосон тоглоомын талбай нь иргэд ашиглах боломжгүй, айлын хашаатай зэрэгцүүлэн булангийн газар байгуулсан нь ойр орчмын иргэдийн дунд бухимдал үүсгэж, талбайг зориулалтаар ашиглаж төсөл арга хэмжээний үр ашгийг хүртэх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Зураг 1 Ашиглахгүй байгаа тоглоомын талбай



- Даланзадгад сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Өглөөний гудамж бий болгох" дэд бүтцийн ажил нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй 1-2 жил дамжсан, гүйцэтгэлийг хангуулж, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр ашиг, үр дүнг хариуцаж ажиллаагүй байна

Зураг 2 Шугам сүлжээний нүх ухаад орхигдсон байдал



- Даланзадгад сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1 дүгээр сургуулийн хөгжмийн кабинетын тоног төхөөрөмж зэрэг ажлууд хийгдэж ашиглалтад орсон боловч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

Зураг 3 Ашиглагдахгүй байгаа тоног төхөөрөмж



- Ханбогд сумын ОНХС-ийн Ханбогд хот тохижилт ОНӨААТҮГ-ын "Цагаан хад суурьшлын бүсэд ашиглах 50 ковш худалдан авах" ажлын хүрээнд нийлүүлэгдсэн ковш одоог хүртэл тээврийн хэрэгслийн гэрчилгээ аваагүй, эд хөрөнгийн өмчлөгч тодорхойгүй байна.
- Ханхонгор сумын эрүүл мэндийн төвийн лабораторийн тоног төхөөрөмж авах төсөл арга хэмжээгээр /Гематологийн бүрэн автомат аппарат, Биохимийн хагас автомат анализатор/ зэрэг аппаратыг ажлын даалгаврын хүрээнд нийлүүлсэн боловч уг тоног төхөөрөмжид нийцэх урвалж бодис ховор, олдохгүйгээс шалтгаалан ашиглах боломжгүй нөхцөл үүссэн байна.

Зураг 4 Ашиглахгүй байгаа хөрөнгө



- "Жижиг дунд үйлдвэрлэлийн барилга өргөтгөх, хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж суурилуулах, хадгалах агуулах барих" ажлыг 599.9 сая төгрөгөөр гүйцэтгүүлэн 2024 оны 12 сард хүлээн авч ашиглалтад оруулсан боловч өнөөдрийг хүртэл зориулалтын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээ явуулаагүй, ашиглаагүй байна

Зураг 5 Ашиглахгүй байгаа хөрөнгө



- Цогтцэций сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах (Уурхайчин)", "Өгөөмөр талбайг шинэчлэн тохижуулах" ажлууд хийгдэж ашиглалтад оруулсан боловч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт алдагдсан байна

Зураг 6 Эвдэрсэн хөрөнгө



2.18. Дээрх зөрчлүүд нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталж, хэрэгжүүлснээс шалтгаалсан байна. Иймд дээрх сумдын Засаг дарга нарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж хүргүүллээ.

2.19. Зарим сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн төсөл, арга хэмжээ нь ОНХС-ын үндсэн зорилгод нийцсэн бусад сумдад сайн жишээ болохоор төсөл арга хэмжээ болсон байна. Тухайлбал:


- Даланзадгад сум: Гурвансайхан гэр хорооллын гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажил нь Даланзадгад хотын өнгө үзэмж нэмэгдүүлэн иргэдийн амар тайван, аюулгүй байдлыг хангаж байна.

Зураг 7 Гурвансайхан хорооллын шөнийн зураг



- Даланзадгад суманд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон нийтийн эзэмшлийн өмч хөрөнгийг хамгаалах, нийтийн эзэмшлийн талбайг камержуулах ажлын хүрээнд Даланзадгад сумын өндөрлөг цэгүүд болон сургууль, цэцэрлэгүүдэд гадна, дотно камерыг суурилан ашиглалт, үр дүнг хариуцан ажиллаж байна. Үүний үр дүнд гэмт хэрэг, ахуйн зөрчил дутагдал буурах сайн талтай юм.

Зураг 8 Камерын хяналтын дэлгэцүүд



- Ханбогд суманд нарны эрчим хүчээр ажилладаг гэрэлтүүлгийг орон нутгийн онцлогт нийцүүлэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.

Зураг 9 Тольтой гэрэлтүүлэг



- Цогтцэций суманд хийгдсэн "Өгөөмөр талбайг шинэчлэн тохижуулах" ажил хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд тохиромжтой тоглоомын цогц бүрдэлтэй талбайг бий болгосон байна.

Зураг 10 Өгөөмөр талбай



БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1 Аймаг, сумдын ИТХ журамд заасан хяналтыг тавьж ажилласан гэх боловч тайлагналт хангалтгүй байна.

3.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд тус тус хяналт тавихаар зохицуулсан байдаг.

3.2 Аудитаар аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх бодлогын хороод, ажлын хэсгийн баримт материалтай тулган баталгаажуулах горим сорил хэрэгжүүлэхэд хяналтын хороод 2024 онд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажилласан гэх боловч тайлагналт хангалтгүй байна.

3.3 Цаашид төсөл арга хэмжээний чанар, үр дүнг хэлэлцэж, илэрсэн алдаа зөрчлийг таслан зогсоох зөвлөмж, дүгнэлт гаргаж, нотлох баримтаар дэмжигдэхүйц хяналтын тайланг гаргаж байх шаардлагатай байна.

3.4 Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн хэдий ч чанар, үр дүнд хангалттай хийгээгүй нь дараах зөрчил илэрч байгаагаас харагдаж байна. Үүнд:

- Номгон сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Өвсний нөөц бүрдүүлэх" 40.0 сая төгрөгийн өртөгтэй 2 ажлыг ажлын даалгаваргүй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилт тооцоогүй,
- Байгуулсан бүх бараа, үйлчилгээ, ажил гүйцэтгүүлэх гэрээнд алданги тооцох тухай заалт тусгаагүй,
- "Угтах хаалганы тохижилт ажил"-ийг батлагдсан зураг төслийг өөрчилж гүйцэтгэхдээ зохиогчтой зөвшилцсон баримт бичиг үйлдээгүй, зохиогчийн хяналтаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй, хогийн сав байршуулаагүй, ширээ суурилуулахдаа бэхэлгээ хийгээгүй,
- "Угтах хаалганы тохижилт ажил"-д хувь хүнээр захиалагчийн хяналт хийлгэж төсвөөс 1.6 сая төгрөгийг зарцуулсан,
- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Төв цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоомын талбайг сайжруулан тохижуулах ажил"-д зураг төсөл батлуулаагүй төлөвлөж, хэрэгжүүлсэн, ажлын тоо хэмжээг заасан боловч гүйцэтгэлийг хангуулаагүй, захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй,
- Ханхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр Барилга байгууламжийг хүлээн авах комисс нь Жижиг дунд үйлдвэрийн барилга өргөтгөх ХАА-н машин тоног төхөөрөмж суурилуулах, хадгалах агуулах барих арга хэмжээний захиалагчийн ажлын зурагт тусгагдсаны дагуу 1 бүргэд хаалга суулгасан, явган замын хашлага, үйлдвэрийн байранд цементэн зуурмаг дээр вааран хавтангаар шал хийх, граж, агуулахын шал резинээ будгаар будах, гадна талбайн төмөр шонтой 6 ширхэг гэрэлтүүлэг угсрах, автомашины зогсоол зэрэг ажлууд хийгдээгүй зөрчилтэй байхад комисс хүлээн авсан, мөн захиалагчийн хяналт хэрэгжүүлж ажиллаагүй,
- Хүрмэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ, ажил гүйцэтгүүлэх гэрээнд магадалшгүй ажил, захиалагчийн хяналтын зардал зэргийг хэрхэн тооцох тухай тусгаагүй байна.

3.5 Дээрх зөрчлүүдэд төлбөр барагдуулах төлбөрийн акт, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүллээ.

3.6 ОНХС-ын хөрөнгөөр хийх төсөл арга хэмжээний тоо, санхүүжилт жил бүр өсөж байгаа тул захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, мэргэжилтнүүдийн чадвар, хүний нөөцөд анхаарах шаардлагатай байна.

3.7 Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газраас ОНХС-ын 2023 оны хөрөнгийн зарцуулалтад 1 төлбөрийн акт, зөрчил арилгах 12 албан шаардлага, 15 зөвлөмж өгснийг Ноён суманд өгсөн төлбөрийн актаас бусад шийдвэр хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт

Зөрчлийн төрөл	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Хэрэгжилт хувь	Тоо	Хэрэгжилт хувь	Тоо	Хэрэгжилт хувь
Зориулалт бусаар зарцуулсан	-	-	1	100	-	-

Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн	-	-	3	100	-	-
Төсөвт өртгөөс илүү санхүүжүүлсэн	1	-	-	-	-	-
ОНХС-ийн УМС-д мэдээллийг байршуулаагүй, зөрүүтэй мэдээлсэн	-	-	4	-	-	-
Дутуу буюу чанаргүй хийгдсэн	-	-	1	100	-	-
Захиалагчийн хяналт тавиагүй	-	-	1	100	-	-
Бусад	-	-	2	100	15	100
дүн	1	100	12	100	15	100

Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь ТАБ-ын 2024 оны хагас эцсийн статистик мэдээ

3.2 Удирдлагын мэдээллийн системд төсөл, арга хэмжээг төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг дутуу, огт оруулдаггүй зөрчил давтан гарсаар байна.

3.8 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2⁶-д заасны дагуу 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланг сумд аймгийн ЗДТГ-ын СТСХ-т журамд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.9 Харин аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ нь дээрх журмын 9 дүгээр зүйлийн 9.9⁷-д заасны дагуу аймаг, сумдын 2024 оны ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж Сангийн яаманд хүргүүлээгүй байна.

3.10 ОНХС-ийн хөрөнгө оруулалт, төсөл арга, хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг сумдын ИТХ-аар тогтоол гаргуулж холбогдох байгууллагуудын хөрөнгөд бүртгүүлсэн байна.

3.11 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 36,074.3 сая төгрөгийн 289 хөрөнгийг ашиглагч байгууллагууд нягтлан бодох бүртгэлд тусгажээ. /Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас/

3.12 Харин ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 71.2 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна. Тухайлбал:

- Баян-Овоо сум 55.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ,
- Манлай сум 198.5 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ,
- Цогтцэций сум 49.7 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ байна.

3.13 Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна. Иймд дээрх зөрчлүүдийг арилгах зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт өглөө.

3.14 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын 10.2⁸-т заасны дагуу tusuv-oronnutag.mof.gov.mn сайтад Өмнөговь аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгө, оруулалт,

⁶ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9- д заасан мэдээллийг багтаана.

⁷ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана.

⁸ ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ.

хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг оруулсан байдлыг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Удирдлагын мэдээллийн системд аймаг 12 төсөл, арга хэмжээ, 7 сум 64 төсөл арга хэмжээг дутуу оруулсан
- Аймаг, 13 сум удирдлагын мэдээллийн системд 114 төсөл арга хэмжээг огт оруулаагүй байна. /Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас/

3.15 Энэ нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод үүрэгдүүлж өгөөгүйгээс орхигдсон, сумдын албан тушаалтнууд журмын мэдлэг дутмагаас болсон байна.

3.16 Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмжийг Засаг дарга нарт хүргүүлээ.

3.17 ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1.1, 6.3.9 дэх заалтуудаар шилэн дансны shilendans.gov.mn цахим сайтад байршуулахаар зааж өгсөн байна. Шилэн дансны нэгдсэн цахим сайтад ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулж ажилласан эсэхийг тулган үзэхэд зөрчил илрээгүй.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Өмнөговь аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 47,716.0 сая төгрөг байхаар баталсан
- Аймаг сумдын ОНХС-ын хөрөнгөөр нийт 415 төсөл арга хэмжээнд 65.97462 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 14,275.0 сая төгрөгийн 126 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна
- Нийт төсөл арга хэмжээний тоогоор 44 хувьд шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь зарим сумд сангийн хөрөнгийг хэт жижиглэж төсвийн байгууллагын урсгал зардлын шинжтэй төсөл арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлж байгаа нь үр өгөөжийг бууруулж байна.
- Аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх бодлогын хороод, ажлын хэсгийн баримт материалтай тулган баталгаажуулах горим сорил хэрэгжүүлэхэд хяналтын хороод 2024 онд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажилласан гэх боловч тайлагналт хангалтгүй байна

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Энхбат танаа:

- Төсвийн тухай хуульд заасан шалгуур болон төлөвлөлтийн бусад шаардлага хангасан төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөх;
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.9, 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

Сүмдын Засаг дарга нарт:

- Төсвийн тухай хуульд заасан шалгуур болон төлөвлөлтийн бусад шаардлага хангасан төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөх;
- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах;
- Хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хууль журмын дагуу чанартай гүйцэтгэх;
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын 10.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/19

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар болон Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.

3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг аудитор (М.Номиндарь)-т, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Шижирболд)-т тус тус даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

4625010358

Р-12.Бичиг хэрэг\2024он\тушаал\Төсөл.Docx

